

Эрдэмтэн Р. Бямбаагийн хэвтээ дөрвөлжин үсгийн судлалын
бүтээлүүдийн тухай

Ё.Жанчив*

Анхдугаар богд Өндөр Гэгээн Занабазар (1635-1723) хоёр зүйлийн монгол бичиг зохиосны нэг нь соёмбо, нөгөөх нь хэвтээ дөрвөлжин үсэг билээ. Хэвтээ дөрвөлжин үсгийн тун цөөн дурсгал олдоод байсан бөгөөд эл үсэг, түүний түүний дурсгалыг судалсан хүмүүс гэвэл П.С.Паллас (1803), И.Клапрот (1814), Д.Банзаров (1848), А.Бобровников (1870), А.Уайли (1870), А.М.Позднеев (1897), Б.Ринчен (1952), Д.Кара (1972, 2005), Ц.Шагдарсүрэн (1981, 1985, 2001) нар болно.¹

1985-86 он болтол хэвтээ дөрвөлжин үсгийн дараахи хэдхэн дурсгал л судалгаа шинжилгээний эргэлтэнд ороод байлаа. Үүнд;

1. Эл үсгийн хэдэн зүйл цагаан толгой
2. Цагаан толгойн эхэнд байх нэгэн самгард тарни
3. Проф. Д.Карагийн 1972 онд олж нийтлүүлсэн "Амгалант тамга"-ын дардас
4. Гавж Т.Данзан-Одсэр (1901-1978) Эрдэнэ-зуугаас олж, проф. Ц.Шагдарсүрэн 1981

*Монгол Улсын Их Сургууль, Гадаад Хэл Соёлын Сургууль

P.S.Pallas, Sammlungen historischer Nachrichten über die mongolischen Völkerschaften, II, S.Pbg., 1803, s. 358, pl. XXIII; J. von Klaproth, Reise in den Kaukasus und nach Georgien unternommen in den Jahren 1807 und 1808. Halle-Berlin, 1814, vol. II, ss.540-541; Д.Банзаров. О двух среднеазиатских алфавитах. In book: Доржи Банзаров, Собрание сочинений, 2-е дополненное, Улан-Удэ, 1997, (239 сс), 59-62; А.Бобровников, Памятники монгольского квадратного письма, ТВОИРАО, т. XVI, Спб., 1870, 1-90 сс; А.Wylie, On an Ancient Buddhist Inscription at Keu-yung-koan, in North China, JRAS, n. s. vol.1, 1870, 14-44; А.М.Позднеев. Лекции по истории монгольской литературы, том II, Спб., 1897, (221 сс+XLI), сс.195-200; Rintschen, Zwei unbekannte mongolische Alphabete aus dem XVII Jahrhundert, АОН, т.II, f.1, Budapest, 1952, 63-71; Д.Кара, Книги монгольских кочевников. М.1972. (194 сс+таб. 26), 93-95, 96; G.Kara, Books of the Mongolian Nomads, More than Eight Centuries of Writing Mongolian, First English Edition, Translated from the Russian by John R.Krueger, Indiana University, Bloomington, Research Institute for Inner Asian Studies, 2005, (331 pp.+XXXVI pls), 168-171; Ц.Шагдарсүрэн, Монгол үсэг зүй, Тэргүүн дэвтэр. УБ., 1981 (168 тал), 98-112; Ц.Шагдарсүрэн, Об одном памятнике горизонтального квадратного письма, "Монгольский лингвистический сборник", М., 1985, (156 сс), 150-153, Рис.8; Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, Bibliotheca Mongolica: Monograph I, Centre for Mongol Studies, National University of Mongolia, УБ., 2001, (300 тал), 159-174

онд анх нийтлүүлсэн шар торгон дээр хар бэхээр, ланз, хэвтээ дөрвөлжин үсгээр самгард, монгол хэлээрхи 31 мөр бичээс бүхий ханын чимэг. Үүний сүүлчийн 31-р мөрийг хэвтээ дөрвөлжин үсгээр, монгол хэлээр бичсэн байдаг.

Проф. Ц.Шагдарсүрэн 1981 онд нийтлүүлсэн номдоо эдгээр дурсгалыг авч үзээд, “Өнөөдрийн байдлаар, хэвтээ дөрвөлжин үсгээр бичсэн дурсгал хэдийгээр хязгаарлагдмал, цөөхөн байгаа боловч цаашид ер олдохгүй гэсний батлагаа бас байхгүйг тэмдэглэе” хэмээн “Хэвтээ дөрвөлжин үсэг” хэмээх бөлгөө төгсгөсөн байдаг билээ.² Түүний эл дүгнэлт ч удалгүй батлагдсан юм.

Судлаач Р. Бямбаа “Монголын судлал” цувралын 1987 оны XIII ботид “Хэвтээ дөрвөлжин үсгийн шинээр олдсон нэгэн дурсгалын тухай” хэмээх өгүүлэл нийтлүүлсэн билээ.³

Эл дурсгал нь Түшээт хан аймгийн Ханд чин вангийн хошуу буюу одоогийн Булган аймгийн Сайхан сумын харьяат Лувсансодовжамц (1878-1961) хэмээх эрдэмт ламын хэвтээ дөрвөлжин үсгийг судалж туурвисан “ཡིག་བཟང་གསལ་བའི་མེ་ལོང་ཞེས་པ་བཞུགས་སོ།། Yig-bśad gsal-ba'i me-long žes bya-ba bžugs-so” буюу “Үсгийн номлол тодорхой толь хэмээх оршивой” хэмээх таван хуудас гар бичмэл судар болно. Энэхүү ховор нандин судрыг Гандантэгчэнлэн хийдийн дэргэдэх Шашны Дээд сургуулийн багш Пүрэвжамц (1905-1986) агсан зохиогчид өгсөн байна. Р.Бямбаа өгүүлэлдээ тус судрын эх бичиг болон зохиогч, номын бүтэц, ерөнхий онцлогийг товч танилцуулж, латин галиг, монгол орчуулга, товч тайлбар сэлт үйлдэн эхийг нь хавсарган хэвлүүлжээ.

Лувсанжамц ламтаны эл бүтээлд хэвтээ дөрвөлжин үсгийн цагаан толгойн үсэг тус бүрийн дор төвд галиг хадаж жагсаан үзүүлээд, монгол, самгард, төвд хэлнээ хэрэглэгдэх үсгүүдийг тусгайлан тайлбарлаж судалснаас гадна “номт гурван хэл”-ээр хэвтээ дөрвөлжин үсгээр бичих жишээ хавсаргажээ. Иймээс эл бүтээл нь нэг талаас уламжлалт буддын боловсролтон хүний тус үсгийг нягтлан судалж туурвисан, одоогоор олдоод буй цорын ганц хэл шинжлэлийн бүтээл, нөгөө талаас, хэвтээ дөрвөлжин үсгээр монгол, самгард, төвд хэлээр бичих жишээ хавсаргасан нь үнэ цэнэтэй дурсгал болох юм.

Ийнхүү Р.Бямбаа ламтан бээр эл бүтээлээрээ хэвтээ дөрвөлжин үсгийн дурсгалын тоог шинээр нэмж баяжуулахын сацуу уул үсгийг судлан шинжлэх үйлсийнхээ гарааг амжилттай эхэлсэн байна. Р.Бямбаа 1987 оноос хойш хэвтээ дөрвөлжин үсгийн дурсгалыг тасралтгүй сурвалжлан судалсны үр дүнд нэлээд хэдэн шинэ дурсгал нээн олж, үүнийхээ үндсэн дээр 1997 онд “Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд” хэмээх ном хэвлүүлсэн нь уг үсгийн судлалд нэн чухал хувь нэмэр болсон билээ.⁴

Зохиогч уул бүтээлдээ уг үсгийн судалгааны тойм болон цагаан толгойн талаар дэлгэрэнгүй танилцуулахын зэрэгцээ хэвтээ дөрвөлжин үсгийн дурсгалыг монгол, санскрит, төвд хэлээр байгаа хэмээн 3 хэсэгт хуваан судлан нийтлүүлжээ. Үүнд, 1987 онд олж хэвлүүлсэн Лувсансодовжамцын “Тодорхой толь” дахь дурсгалаа энд дахин оруулсантайгаа нийлээд

² Ц.Шагдарсүрэн, *Монгол үсэг зүй*, УБ., 1981, (168 тал), 110-р тал

³ Р.Бямбаа, *Хэвтээ дөрвөлжин үсгийн шинээр олдсон нэгэн дурсгалын тухай*, SM, т.XIII (21), УБ., 1987 (86), (176 тал), 132-149

⁴ Р.Бямбаа, *Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд*, Эрхилсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 1997, 89 тал

“Хутагт Жавзандамба ламын цадиг оршивой” хэмээх 7 хуудас томоохон судар зэрэг монгол хэлний 2 дурсгал, Бурхан багшийн айлдсан “Пунсүм-цогма” буюу “Өлзий хутаг оршуулах” хэмээн 8 хуудас судар, хэд хэдэн жижиг тарни тэргүүтэн самгард хэлний 9 дурсгал, товд хэлний 4 жижиг бичээс зэрэг нийт 15 дурсгалыг шинээр олж, судлан нийтлүүлсэн нь хэвтээ дөрвөлжин үсгийн судлалд томоохон нээлт, шинэ эргэлт гаргасныг онцлон тэмдэглэмээр байна.

2000 онд Р.Бямбаа ламтан “Монгол хэлээр байгаа хэвтээ дөрвөлжин үсгийн дурсгалууд” хэмээх өгүүллийг Буриадын Улаан-Үдэ хотноо нийтлүүлжээ.⁵ Зохиогч эл бүтээлдээ 1997 оны номынхоо “Монгол хэлээр байгаа хэвтээ дөрвөлжин үсгийн дурсгалууд”⁶ хэмээх бэлнийг бүхлээр нь хэвлүүлжээ.

Тэр бээр 1997 оны “Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд” номоо нэмэн засварлаж, 2005 онд “Занабазарын дөрвөлжин үсэг” хэмээх ганц сэдэвт бүтээлээ туурвижээ.⁷ Энэхүү бүтээлд соёмбо үсгийн нэгэн ховор нандин судрын 13-р хуудасны төгсгөлд оруулсан хэвтээ дөрвөлжин үсгээр, монгол хэлээр тэмдэглэсэн 9 мөр бичээс бүхий тамгын дардас мэт монгол хэлний 1 дурсгал; маанийн зургаан үсэг болон Чулууны номын тарнийг ланз, төвд, соёмбо, хэвтээ дөрвөлжин үсгээр бичсэн дардас; ланз, төвд, соёмбо, хэвтээ дөрвөлжин үсгээр үйлдсэн Наро Хажод бурханы найман мөрт магтаал тарни зэрэг самгард хэлний 2 дурсгал; Архангай аймгаас олдеон 5 хуудас ланз, соёмбо, хэвтээ, босоо дөрвөлжин үсгийн гар бичмэл цагаан толгой; төвд үсгийн цагаан толгойн хоёр хуудас номын төгсгөлд эл үсгээр үйлдсэн ганц бичээс болон цагаан толгой зэрэг төвд хэлний 2 дурсгал зэрэг нийт 5 дурсгалыг шинээр олж, судлан нийтлүүлжээ. Түүнчлэн эдийн засгийн ухааны доктор Д.Төмөртоогоогийн хүсэлтээр МУИС-ийн багш, доктор, Г.Гантогтохын хэвтээ дөрвөлжин үсгээр сийрүүлэн бичсэн “Билиг барамидийн зүрхэн” хэмээх судрын уламжлалт монгол орчуулгыг номдоо хуубарлан оруулсан буй.

Ийнхүү “Занабазарын дөрвөлжин үсэг” номд эдүгээ мэдэгдээд буй хэвтээ дөрвөлжин үсгийн бараг бүх дурсгал буюу 1997 оны ном гарахаас өмнө мэдэгдэж байсан 3, 1997 оны бүтээлдээ шинээр оруулсан 15, эл бүтээлд нэмэгдэж орсон 6, нийт 24 дурсгалыг бүх талаас нь судлан шинжиж, латин галиг, хөрвүүлэг, гэрэл зураг, тайлбар, судалгаа сэлтийг багтаажээ.

Р.Бямбаа ламтан 1997 оны номынхоо бараг бүх алдаа мэдгийг засварлаж, дахин нягталж, нарийн шүүсний эцэст энэ номоо туурвисан нь олон зүйлээс тодорхой харагдана. “Занабазарын дөрвөлжин үсэг” ном өнгө зүс, хэв загвар, хийц дизайн, зураг хорог, хэвлэлийн чанар сэлтийн хувьд өмнөх 1997 оны номтой нь жишихийн аргагүй сайн болсоныг тэмдэглэе.

Тус номын бүтэц агуулгыг авч үзвэл;

Зураг хүснэгтийн жагсаалт

Эрхлэн нийтлүүлэгчийн үг /анхдугаар хэвлэл/ (3-р тал)

⁵ Р.Бямбаа, *Монгол хэлээр байгаа хэвтээ дөрвөлжин үсгийн дурсгалууд*, В книге: “Культура Центральной Азии: Источники”, Вып. 4, Улан-Удэ, 2000, (175 сс.), 40-59

⁶ Р.Бямбаа, *Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд*, УБ., 1997, (89 тал), 42-61

⁷ Р.Бямбаа, *Занабазарын дөрвөлжин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхлэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, 146 тал

Эрхилэн нийтлүүлэгчийн үг /нэмэн зассан хоёрдугаар хэвлэл/ (4-5-р тал)

Өмнөх үг /Англи/ (6-7-р тал)

Талархал (8-р тал)

Оршил (9-10-р тал)

Нэгдүгээр бүлэг. Занабазарын дөрвөлжин үсэг (11-56-р тал)

1.1. Занабазарын дөрвөлжин үсгийн уг гарал хийгээд нэрийн тухай (13-16-р тал)

1.2. Занабазарын дөрвөлжин үсгийн судлалын тухай (17-18-р тал)

1.3. Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгой (19-36-р тал)

1.4. Занабазарын дөрвөлжин үсгийн нэгэн тайлбар (37-52-р тал)

1.5. Зүүлт тайлбар (53-56-р тал)

Хоёрдугаар бүлэг. Занабазарын дөрвөлжин үсгээр бичсэн монгол хэлний дурсгал (57-90-р тал)

2.1. Занабазарын дөрвөлжин үсгээр бичсэн монгол хэлний дурсгалууд (59-р тал)

2.2. Занабазарын дөрвөлжин үсгээр бичсэн монгол хэлний жижиг дурсгалууд (60-64-р тал)

2.3. Занабазарын дөрвөлжин үсгээр бичсэн монгол хэлний том дурсгалууд (65-87-р тал)

2.4. Зүүлт тайлбар (88-90-р тал)

Гуравдугаар бүлэг. Занабазарын дөрвөлжин үсгээр бичсэн санскрит хэлний дурсгал (91-114-р тал)

3.1. Занабазарын дөрвөлжин үсгээр бичсэн санскрит хэлний дурсгалууд (93-р тал)

3.2. Занабазарын дөрвөлжин үсгээр бичсэн санскрит хэлний жижиг дурсгалууд (94-99-р тал)

3.3. Занабазарын дөрвөлжин үсгээр бичсэн санскрит хэлний том дурсгалууд (100-105-р тал)

3.4. Зүүлт тайлбар (106-р тал)

Эхийн гэрэл зургууд (107-114-р тал)

Дөрөвдүгээр бүлэг. Занабазарын дөрвөлжин үсгээр бичсэн төвд хэлний дурсгал (115-124-р тал)

4.1. Занабазарын дөрвөлжин үсгээр бичсэн төвд хэлний дурсгал (117-119-р тал)

4.2. Зүүлт тайлбар (120-р тал)

Эхийн гэрэл зургууд (121-124-р тал)

Summary in English. Zanabazar Quadratic Script (125-132-р тал)

Хавсралт (133-140-р тал)

Ном зүй (141-142-р тал)

Индекс (143-146-р тал) болой.

Бид энд уул бүтээлийг 1997 оны анхны хэвлэлтэй нь харьцуулан, шинээр авч үзсэн. Засварласан, нэмэн дэлгэрүүлсэн зүйлийнх нь талаар голчлон авч үзэхийг чармайлаа.

Р.Бямбаа ламтан эл бүтээлдээ тус үсгийн нэрийн тухайд, "...Энэ үсгийг бас "Дөрвөлжин үсэг" гэж нэрлэх нэгэн үндэс бол Номгоны Дара эх лам Агваанцүлтэмжамцын туурвисан дээр нэр дурдсан Богд Живзүндамба хутагтын намтарт уг үсгийг *hor yig gru bzhi pa* "Монгол дөрвөлжин үсэг" гэсэн, мөн Бээжин богино модон барын уг үсгийн нэгэн цагаан толгойн нүүрэн тал дээр хар бэхээр төвд үсгээр *иге-дүши* "yi-ge gru bzhi" буюу монголоор орчуулбал "дөрвөлжин үсэг" гэж тэмдэглэсэн байгаагаас үзвэл уг үсгийг урьд "дөрвөлжин үсэг" гэж

нэрлэж байсан ажээ.” хэмээн⁸ тэмдэглээд, “хэвтээ дөрвөлжин үсэг” хэмээх нэрийг акад. Ринчен 1952 оны өгүүлэлдээ анх өгсөн хэмээн таамаглан⁹, “Миний бодлоор Өндөр Гэгээн Занабазарын зохиосон “Дөрвөлжин үсэг”-ийг “Хэвтээ дөрвөлжин үсэг” гэж нэрлэсэнээс түүний олонд алдаршсан санскрит алдраар нь “Занабазарын Дөрвөлжин үсэг”, эсвэл “Өндөр Гэгээний дөрвөлжин үсэг” гэж нэрлэвэл илүү зохимжтой болов уу гэсэн саналыг дэвшүүлж байна”¹⁰ хэмээн тэмдэглэсэн буй.

Академич Б.Ринчен 1952 онд Мажар улсад нийтлүүлсэн өгүүлэлдээ анх хэвтээ дөрвөлжин үсгийг 1686 онд зохиосон хэмээн бичсэн¹¹ бөгөөд тэр бээр ямар баримт нуталгааг үндэслэлийн бичсэнийг нь бид олохгүй байгаагаа урьд өмнө нь дурдаж байсан билээ.¹²

Гэтэл Р.Бямбаа эл бүтээлдээ энэ үсгийн он цагийн талаар анхаарал татахуйц баримт дурджээ. Үүнд:

“Түшээт хан аймгийн Очирай Түшээт ханы хошууны Номгоны Дара эх лам Агваанцүлтэмжамц /Ngag dbang tsul khri ms rgya mtso, 1880-1938/-ын 1925 онд зохиосон *Живзүндэмлын торлийн үеүдийн намтарыг товчилон хураангуйлж өгүүлсэн сүсэгтэн бүгдийг баясагч үзэсгэлэнт чимэг* хэмээх намтарт ‘Гал барс жилийн хавар Ханчин Чойжал тэргүүтэн олон орчуулагчдыг цуглуулан Шалүгийн *Дагег самадогийг* монгол хэлнээ орчуулуулж, Богдын өөрийн арилсан таалалын үзэгдэлд хэрхэн ургасанчиан гайхамшигт монгол үсэг *сваямбху жэти* хэмээхийг бас энэ үед зохиосон. Түүнээс өмнө Монгол дөрвөлжин үсэг Төвдийн *хор-ег* лүгээ адил нэгийг ч зохиосон үзэгдэнэ’ /me stag lo`i dpyid ka mkhan chen chos rgyal sogs lo tza` shes mkhan mang po bsags nas zha lu`i yig za ma tog sog skad du bsgyur ba gnang zhing / rje nyid kyi dag pa`i gzigs snang la ji ltar shar ba ltar gyi sog yig ngo mtsar can swa yam` bhu dzyoti zhes pa yang de dus mdzad / de gong hor yig gru bzhi pa bod kyi` khor yig dang cha`dra ba zhis kyang mdzad snang / хэмээснээс үзвэл “гал барс жилийн хавар” гэж жилийн махбодыг улирлын хамт заасан ба энэ нь нийтийн он тооллын 1686 оны хавар бөгөөд энд Шалу лозавагийн төвд хэлний тайлбар толь *Дагег самадогийг* орчуулах үед соёмбо үсгийг зохиосон нь тодорхой болж байна. “Түүнээс өмнө Монгол дөрвөлжин үсэг Төвдийн *хор-ег* лүгээ адил нэгийг ч зохиосон” гэсний “түүнээс өмнө” гэсэн нь соёмбо үсгийг зохиохоос өмнө. “Монгол дөрвөлжин үсэг” гэсэн нь бидний энд өгүүлж байгаа Өндөр Гэгээний зохиосон дөрвөлжин үсгийг хэлж байгаа бөгөөд “Төвдийн *хор-ег*” гэдэг нь Пагба ламын зохиосон “дөрвөлжин үсэг”-ийг хэлж байгаа ба “лүгээ адил” гэснээр хэлбэрийн хувьд “*хор-ег*” үсэг лүгээ нэгэн адил “дөрвөлжин үсэг”-ийг Өндөр Гэгээн зохиосон болохыг батлан хэлж байгаа ажээ.

⁸ Р.Бямбаа, *Занабазарын дөрвөлжин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхлэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 16

⁹ Р.Бямбаа, *Занабазарын дөрвөлжин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхлэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 16-р тал

¹⁰ Р.Бямбаа, *Занабазарын дөрвөлжин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхлэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 16

¹¹ Rintchen, *Zwei unbekannte mongolische Alphabete aus dem XVII Jahrhundert*, АОН, т.И, f.1. Budapest. 1952, (ss. 63-71), 66

¹² Ё.Жанчив, *Хэвтээ дөрвөлжин үсгийн судлалын асуудалд*, МУИС, МСДС, ЭШБ, УБ., 1998, 12 (135)-р боть, (202 тал), [тал 166-179], 168; Ё.Жанчив, *Хэвтээ дөрвөлжин үсэг, “Төв Азийн нүүдэлчдийн бичиг үсгийн товчоон”*, Редактор Л.Болд, Ж.Бат-Ирээдүй, УБ., 2001, (328 тал), [тал. 287-304], 291

Энд бусад сурвалж бичгүүдэд гардаггүй анхаарал татсан чухал зүйлүүд ажиглагдаж байгаа нь Өндөр Гэгээн соёмбо үсгээ зохиохоос өмнө дөрвөлжин үсгийг зохиосон гэдгийг тодорхой өгүүлэхийн хамт уг үсгийн нэрийг бас “Монгол дөрвөлжин үсэг” гэж нэрлэсэн байна. Харин Номгоны Дара эх лам Агваанцүлтэмжамц дөрвөлжин үсгийг зохиосон цаг хугацааг соёмбо үсэг зохиохоос өмнө гэсэн боловч яг ямар жил болохыг тодорхой дурдаагүй нь хэцүү асуудал боловч “түүнээс өмнө” гэсэн нь “гал барс жил”-ээс өмнө “арван нэгдүгээр жарны хөхөгчин үхэр” жил буюу 1685 оныг ч хэлсэн байж болох талтай [15] юм. Үүнээс гадна Пагба ламын дөрвөлжин үсгийг төвдөөр “bod kyi 'khor yig” гэж тэмдэглэсэн нь анхаарах асуудлын нэг юм.

Номгоны Дара эх лам Агваанцүлтэмжамц нь хэдийгээр харьцангуй хожуу үеийн хүн боловч Занабазарын дөрвөлжин үсгийг зохиосон цаг хугацааг тодруулж өгсөн, мөн Пагба ламын зохиосон “хор-ег” үсгээс ялгахын тухайд уг үсэгт нэр өгсөн зэрэг нь ямар нэг мэдээ баримт, ном сударт тулгуурласан байх нь гарцаагүй юм. Энэ нь Өндөр Гэгээн соёмбо үсэг зохиох үед дөрвөлжин үсэг зохиосон гэж бичсэн сурвалж бичгүүд болон судлаачдын судалгааг нэг талаар улам тодотгосон мэт боловч; нөгөө талаар няцаасан мэт тул дахин нягтлан судлууштай зүйлүүдийн нэг болж байна. Нөгөө талаар энэ сурвалж бичигт өгүүлсэн зүйл гарцаагүй батлагдвал “Бид хэвтээ дөрвөлжин үсгийг зохиосон цаг хугацааны талаар ямар нэг сурвалж бичгийн баримт мэдээ олсонгүй”, “Хэвтээ дөрвөлжин үсгийг зохиосон он цаг мөн л оньсого хэвээр үлдэж байгаа”¹³ гэсэнд хариу болох буй за”¹⁴ гэжээ.

Р.Бямбаа абугайн олж тодруулсан энэхүү мэдээ бол маш чухал юм. Ямар ч байсан тус үсгийг зохиосон он цагийн талаархи одоо мэдэгдэж буй анхны зам чийр хэмээн үзүүштэй. Цаашид үүнийг тодруулан нягтлах шаардлагатай юм.

“Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгой” хэмээх хэсэгт эдүгээ болтол олдоод буй уул үсгийн 5 зүйл цагаан толгойн талаар товч дурдаж, гэрэл зургийг нь хавсаргажээ. (Тус номын 33-35-р тал). Ингэхдээ Занабазарын дөрвөлжин үсгийн цагаан толгойг проф. Ц.Шагдарсүрэнгийн судалгааг үндэслэн жагсаасан байна. (24-32-р тал).

Энэ хэсэгт 1997 оны номоосоо ялгарах зүйл гэвэл 42-р үсгийг Ц.Шагдарсүрэн багшийн саналын дагуу 1997 оны бүтээлдээ:

“42. **ᠮ** tl. sans, Ṣ(a);
tc. sans. ṣa(?)

Самгард хэлний ṣa(?) гийгүүлэгчийн fi хэлбэр нь”¹⁵ хэмээн буруу галигласан байснаа засварлан,

“42. **ᠮ** tl. tib. W(a); sans. (semi-vowel) V(a)

tc. tib.wa, sans. (semi-vowel) va. Төвд хэлний wa, санскрит хэлний тал (буюу хагас) va гийгүүлэгчийн бие даасан буюу (f) хэлбэр”¹⁶ гэжээ.

¹³ Ё.Жанчив, “Хэвтээ дөрвөлжин үсгийн судлалын асуудал”, МУИС, МСДС-ийн Эрдэм шинжилгээний бичиг, Том. XII /135/, Fasc. XII, УБ., 1998, 166-179-р тал

¹⁴ Р.Бямбаа, *Занабазарын дөрвөлжин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, I боть, Эрхилэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 14-15

¹⁵ Р.Бямбаа, *Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд*, Эрхилсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 1997, (89 тал), 19

¹⁶ Р.Бямбаа, *Занабазарын дөрвөлжин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, I боть, Эрхилэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 29

Энэ үсгийг хэрхэн ухаарнаас шалтгаалан 1997 оны номд орсон санскрит хэлний 7 дахь дурсгал болох нэгэн тарнийг “ ha nu śa śa śa ra hi swū hā” хэмээн ташаа галигласан бол¹⁷ эл бүтээлд “ ha nu va śa va ra hi svā hā” гэж зөв тэмдэглэжээ.¹⁸

“42-р үсэг “va” учраас 25-р үсгийг,

□ tl. mong. V(a)

tc.mong.va. Монгол хэлний va гийгүүлэгчийн бие даасан буюу (IF) хэлбэр¹⁹ хэмээн галигласныг “ba” болгон засварлах шаардлагатай юм.

Зохиогч бээр цагаан толгойнхоо жагсаалтын төгсгөлд “Эдгээр үсгүүд дээр нэмэлт болгон цагаан толгойд бичигдэнгүй ч бусад сурвалжуудад гарсан зарим нэгэн санскрит, төвд хэлний үсгийн зүйлүүдийг жагсаавал;” хэмээн²⁰ 67-72-р үсгүүдийг эл бүтээлдээ шинээр нэмж оруулсан нь 1998 онд бидний тодруулсантай нийцэж байгаа билээ.²¹

“Занабазарын дөрвөлжин үсэг” номынхоо “Занабазарын дөрвөлжин үсгийн нэгэн тайлбар” хэмээх хэсэгт²² 1987 онд хэвлүүлсэн Лувсансодовжамц ламтаны “Тодорхой толь”-ийн судалгаагаа оруулжээ. Ингэхдээ тус судрын монгол орчуулгаа нэлээд сайжруулсан боловсруулсан байна. Үүнийг нутлахын тулд хоёр орчуулгыг харьцуулан ажиглая.

1.б. (1) Лам дор мөргөө.

Хотол гурван лагшингын дээд суурийг олсон боловч

Санасанчилэнгээр хоёрдугаар бурхан Лувсандагвын

Шашны дуузыг баригчийн дээд болсон

(2) Ариун богд ламын өлмий дор мөрөгсүгэй.

Бид нарыг тийн татагч ганц дээд ариун богд Лувсандамбийжалцан оор алдар нь

бясаллагч Занабазар буюу

(3) Ранжүн- Ишдоржбалсамбуу бээр зохиосон үсгээс оороо аяндаа гарсан “Соёмбо”

хэмээгч үсэг нь их алдаршсан богоод үсэг бусдыг зохиосон нь энэ богдын шавийн ахмад

(4) мөргөн шидгийн эрх баялаг Заяа бандида Лувсангэрэнлэйбалсамбуу бээр богд өөрийг нь зарлиг хэсэг бусаг тархайг хамтад хурааж хэвлэлд гаргасан богоод хэвлэлийн тэмдэг

(5) ерөөлийг богд энэ маягтаас (ямагтаас, Ё.Ж) дурдсан лугаа сэлт богдын сэрүүн тунгалаг байх цагт бүтээсний сүүлд байгаа нь энэ мэт богоод ...”²³

¹⁷ Р.Бямбаа, *Хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалууд*, Эрхилсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 1997, (89 тал), 66

¹⁸ Р.Бямбаа, *Занабазарын дөрвөлжин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхилсэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 98

¹⁹ Р.Бямбаа, *Занабазарын дөрвөлжин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхилсэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 28

²⁰ Р.Бямбаа, *Занабазарын дөрвөлжин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхилсэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 32

²¹ Ё.Жанчив, *Хэвтээ дөрвөлжин үсгийн судлалын асуудалд*, МУИС, МСДС, ЭШБ, УБ., 1998, Боть 12 (135), (тал. 166-179) огүүлэл дэх самгард эгшингийн галигийн хүснэгт дэх 15,16-р үсэг, самгард гийгүүлэгчийн галигийн хүснэгт дэх 31, төвд гийгүүлэгчийн галигийн хүснэгт дэх 9,10,11-р үсгүүдийг харьцуулж үзнэ үү.

²² Р.Бямбаа, *Занабазарын дөрвөлжин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхилсэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 37-51

²³ Р.Бямбаа, *Хэвтээ дөрвөлжин үсгийн шинээр олдсон нэгэн дурсгалын тухай*, SM, I.XIII(21), УБ., 1987 (86), (тал. 132-149), 138-р тал

1.б. (1) Лам дор мөргөө!

Хотол чуулсан гурван лагшины дээд хутагыг (хутагийг, Ё.Ж) олсон чиг
Санасанчилан хоёрдугаар бурхан Лувсандагвагийн
Шашины дуазыг баригчийн манлай болсон

(2) Гэтэлгэгч богд ламын өлмий дор мөргөмүү.

Бидний ганц удирдагч Богд Лувсандамбийжалцан, өөр алдар нь Ёги Занабазар буюу

(3) Ранжүн Ишдорж бээр зохиосон үсгээс оороо гарсан гэгээ хэмээх соёмбо үсэг нь
ихэд алдартай бөгөөд өөр үсгийг ч зохиосон нь Богдын шавь нарын ахмад

(4) мэргэн шидтэний эрх баялаг Зая бандида Лувсанпиринлэй (1642-1716) бээр
Богдын хэсэг бусад зарлигыг (зарлигийг, Ё.Ж) эмхэтгэн хэвийг бүтээж, Богдоос
оорөөс нь дурдтгасан

(5) хэвийн оршил ерөөл лүгээ сэлтгэйгээр Богдыг сэрүүн тунгалаг байх цагт
хэвлэсний сүүлд байгаа нь энэ мэт бөгөөд ...²⁴

(6) . . .ga-ийн аймгаас эцсийг барагдах хүртэл

(7) хорин үсгийг эр үсэг, гийгүүлэгч буюу нэр үсэг, орны үсэг, гаднах үсэг хэмээсэн
бөгөөд учир нь:²⁵

(6) . . .ga-ийн аймгаас адгийн үсгийг хүртэл

(7) хорин нэгэн үсгийг эр үсэг, гийгүүлэгч буюу нэрийн үсэг, орны үсэг, гадаад үсэг
хэмээсэн бөгөөд ...²⁶

“(7) Үүгээр жишиж энэ богд бээр шашин

Амьтаны тусд таалж юу зохиосон бүх нь

Гурван ертөнц бүгдэд түгж амьтан бүхний

Тус амгалангийн цогт дэлгэрч үйлдэх болтугай”²⁷

“(7) Үүгээр бэлгэдэж Богд лам бээр шашин ба

Амьтны тусыг таалан аливаа зохиосон бүхэн

Хотол гурван ертөнцөд түгж амьтан бүхний

Тус амгалангийн цог болон дэлгэрэх болтугай”²⁸

Мөн 2005 оны номдоо Лувсанжамцын зохиолын төгсгөлд байх санскрит, төвд хэлээр бичсэн тарин болон ерөөлийг монгол орчуулгадаа галиглан, төвд ерөөлийг нь монголоор хадан орчуулжээ.²⁹

Лувсансодовжамцын бүтээлийн судалгааг ийнхүү дахин хэвлүүлэхдээ зарим нэгэн шинэ мэдээ занги нэмж оруулсан буй. Тухайлбал, 1997 оны номдоо “Лувсанжамц бол хуучин

²⁴ Р.Бямбаа, *Занабазарын дорволжит үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхлэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 45

²⁵ Р.Бямбаа, *Хэвтээ дорволжит үсгийн шинээр олдсон нэгэн дурсгалын тухай*, SM, т.XIII (21), УБ., 1987 (86). (тал. 132-149), 139-140

²⁶ Р.Бямбаа, *Занабазарын дорволжит үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхлэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 46

²⁷ Р.Бямбаа, *Хэвтээ дорволжит үсгийн шинээр олдсон нэгэн дурсгалын тухай*, SM, т.XIII (21), УБ., 1987 (86). (тал. 132-149), 141

²⁸ Р.Бямбаа, *Занабазарын дорволжит үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхлэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 47

²⁹ Р.Бямбаа, *Занабазарын дорволжит үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхлэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 48

Түшээт хан аймгийн Чин вангийн хошуу (Одоогийн Булган аймгийн Сайхан сумын нутаг)-ын хүн бөгөөд 1878 онд төрж 1961 (1960) оны үед нас барсан бололтой байна.” (24-р тал) гэсэн бол 2005 оны номдоо; “Лувсансодовжамц бол хуучин Түшээт хан аймгийн Ханд чин вангийн хошуу, одоогийн Булган аймгийн Сайхан сумын нутгийн хүн юм. ХҮ жарны гал нохой жил буюу 1886 онд Номхон бичээчийн хүү Наваан хамбын үеэл эгч Чойжавын хүү болон мэндэлсэн гэдэг.³⁰ Харин багш ХҮ жарны шороон барс жил, 1878 онд мэндэлж, 1961 (1960) оны үед жанч халсан гэж дурсан ярьж байсан.”³¹ гэх мэт.

Эрдэмт лам Р.Бямбаа бүтээл туурвилдаа хичнээн нарийн чанд ханддагийг 1997, 2005 оны номуудыг зах зухаас нь харьцуулан үзмэгц л тодорхой мэдэгдэнэ. Тухайлбал, хэл найруулгаа ч ихэд анхаарчээ. Жишээ нь;

“...Харин зохиогчийн амьдарч байсан үе болон аман мэдээнээс үзвэл зохиогч уг зохиолоо 1900 оны эхээр зохиосон бололтой бөгөөд энэ нь ч түүний ихэнх зохиолоо бичсэн үетэй тохирч байгаа юм.”³²

“Харин зохиогчийн тухай аман мэдээнээс үзвэл Лувсансодовжамц нь уг бүтээлээ 1900-ээд(1900-аад, Ё.Ж.) оны эхээр зохиосон бололтой байгаа бөгөөд энэ нь ч түүний ихэнх бүтээлээ туурвисан цаг үетэй тохирч байгаа юм.”³³

“... Эдгээрээс үзэхэд Лувсанжамц нь ... бусад олон ухааны талаар нилээд бүтээл зохиосон байна.”³⁴ “Тэдгээр бүтээлүүдээс үзэхэд Угалзын лам Лувсансодовжамц ... шашины зан үйлийн талаар нилээд бүтээл туурвисан байна.”³⁵

Хэл найруулгын засвараас өөр жишээ татахул;

“49-р талын дороосоо 10-р мөр:

1. b. (1) a-bu-ra-lain o-ou-tu...”³⁶

“70-р тал, дээрээсээ 5-р мөр:

1. b. 1. //a-bu-ral sain o-yo-tu...”³⁷

“50-р тал дээрээсээ 1, 2-р мөр:

1. b. (5)... ten-ge-ri ga-jar de-le-kei bu-gu-de-dur yam-bar ba el-deb ši-di-gī ö-be-run...”³⁸

“**1. b. 5.** .../ten-ge-ri ga-zar de-le-kei bü-gü-de-dur yam-bar ba el-dev ši-di-gī ö-be-[-]...”³⁹

гэх мэтчилэн олон жишээ татаж болох юм.

³⁰ “Баригдсан лам, олзлогдсон Япон хоёр яг ижил түвшинд үнэлэгдэж байв”, *Ноцтой мэдээ*, №37/125, 10-р нүүр

³¹ Р.Бямбаа, *Занабазарын дорволжсин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхилэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 38

³² Р.Бямбаа, *Хэвтээ дорволжсин үсэг, түүний дурсгалууд*, Эрхилсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 1997, (89 тал), 22

³³ Р.Бямбаа, *Занабазарын дорволжсин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхилэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 37

³⁴ Р.Бямбаа, *Хэвтээ дорволжсин үсэг, түүний дурсгалууд*, Эрхилсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 1997, (89 тал), 24

³⁵ Р.Бямбаа, *Занабазарын дорволжсин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхилэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 40

³⁶ Р.Бямбаа, *Хэвтээ дорволжсин үсэг, түүний дурсгалууд*, Эрхилсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 1997, (89 тал), 49

³⁷ Р.Бямбаа, *Занабазарын дорволжсин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхилэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 70

³⁸ Р.Бямбаа, *Хэвтээ дорволжсин үсэг, түүний дурсгалууд*, Эрхилсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 1997, (89 тал), 50

³⁹ Р.Бямбаа, *Занабазарын дорволжсин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, 1 боть, Эрхилэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 70

Энэхүү чухал бүтээлийг хэд дахин нягтлан унших явцад цөөвөр зарим (ихэвчлэн техникийн шинжтэй) алдаа эндэл олсоноо зохиогчийн “Миний хувьд монгол хэлний мэргэжлийн судлаач биш тул энэхүү номонд (номд. Ё.Ж.) алдаж эндүүрсэн зүйл байх нь магад тул эрдэмтэн мэргэд та бүхэн тунгалаг мэргэн оюуныхаа гэгээн мэлмийгээр таалан болгоож, алдаж эндүүрсэн зүйл бүхнийг ариутган шүүж, засаж залдуулан үнэт шүүмж зөвлөгөөгөө харамгүй хайрлана буй за”⁴⁰ гэсэн хүслийн дагуу энэхүү нандин туурвилыг цаашид улам төгөлдөржүүлэх сэтгэлийн үүднээс доор жагсаавал:

Хуудас	мөр		Ташаарсан нь	Залруулсан нь
	доороос	дээрээс		
3		3	нүүдэлчин	нүүдэлч
3		3-4	монгол бичигийн	монгол үсэг бичгийн
3		5	Иөншөөбү	Йөншөөбү
3		5-6	начрыг нь	начры нь
3		6	эдүүгээ	эдүгээ
3		7	судалсаар	судласаар
3		10	бичигийн (2 удаа)	бичгийн (2 удаа)
3		12	төвд	төвөд
3		13	нуталгаа	нутлагаа
3		14	нэгэн салбар үсэг зүй	нэгэн салбар-үсэг зүй
3	3		Доктор. Ц. Шагдарсүрэн	Ц. Шагдарсүрэн.
10		13	туршлаган дээрээ	туршлага дээрээ
17		5	mongolischen Volkerschaften	mongolischen Völkerschaften
17	9		“Горизонтально квадратного письма”	“алфавит горизонтального квадратного письма”
18		22	2000	2001
18		27	<i>Монголчуудын үсэг бичигийн товчоо</i>	<i>Монголчуудын үсэг бичигийн товчоон</i>
18		28	“хэвтээ дөрвөлжин үсэг”	“хэвтээ дөрвөлжин бичиг”
28	8		ʃ ha	ʃha
40	14		qün	gün
40	13		tagalal-un	ʔagalal-un
41		3	ʔphan	ʔphang
41		12	thor	ʔthor
41		18	ö	ȫ
41		23	-	zhes so
41	9		sa (2 удаа)	sha (2 удаа)
41	8		ʔjug	mjug
41	2		kyis shes	kyis kyang shes

⁴⁰ Р.Бямбаа, *Занабазарын дөрвөлжин үсэг*, Монгол билиг, Эрдэм шинжилгээний бүтээл, I боть, Эрхилэн нийтлүүлсэн Ц.Шагдарсүрэн, УБ., 2005, (146 тал), 10

42		7	gzug [gzugs]	gzugs
42	18		gsal pa'i phyir	gsal zhing drag pa'i phyir
42	11		lta bu drug/	ltar drug go
42	10		brtzeg las	brtzeg gnyis las
42	9		dbyang	dbyangs
42	7		sten	steng
43		2	can rnam	can gzhan rnam
43		5	sogs pa ga ka	sogs pa'i ga ka
43	11		skad lāntza	skad dang lāntza
48		7	ламы зохиол үйлс	ламын зохиол үйлс
53	15		-yien	-iyen
54	28		mongolishen Volkerschaften	Mongolishen Völkerschaften
54	27		1801, ...platte XXII	1803, ...plate XXIII
54	26		Reis	Reise
54	24		среднеазиатских	среднеазиатских
54	12		Об одном новонайденном памятнике...	Об одном памятнике ...
54	11		стр. 150-154	стр. 150-153
54	3		<i>Монголчуудын үсэг бичигийн товчоо</i>	<i>Монголчуудын үсэг бичигийн товчоон</i>
55	6		"Mongolcud-un töbed kele ber jokiyaysan jokiyalun jüül"	"Mongyolcud-un töbed kele-ber jokiyaysan jokiyal-un jüül"
55	2		159-174-р тал	129-158-р тал
59	6		XVII-IX	XVII-XIX
59	1		зургаан зүйлийн дурсгалуудыг	зургаан зүйлийн дурсгалыг
63		3	2.ci a-nu	2.či a-nu
63		7	6.cü a-li-madeta-ber	6.čü a-li-mad ta-ber
63		8	tu-lad	tu-la-da
63		9	ö-börun	ö-bö-rün
70		5	čüg-tür	jüg-tür
70		7	ba-rig-ci-dun	ba-rig-či-dun
70		7	a-ci-tu	a-či-tu
70		10	Na-gan-ču-nain	Na-gan-ju-nain
70		11	čag-tur	cag-tur
70		19	tus	tu-sa
70		21	čag-tur	cag-tur
70		23	mor-gū-gū-lun	mör-gū-gū-lun
70		24	ta-nin	ta-ñin
70		24	ja-lig [jar-lig]	za-lig [zar-lig]
70		27	ka-ba-čal	ka-ba-cal

70	8		u-čül-joi	u-zül-jō
70	8		ča-su-tu	ca-su-tu
70	8		gag-čar	gag-cār
70	7		čag-dur	cag-dur
70	5		nigen	ñi-gen
70	3		čag	cag
70	2		čag-du-ni	cag-du-ni
70	1		ča-su-tu	ca-su-tu
70	1		de-yan-ci	de-yan-či
70	1		bol-ci	bol-ji
71		1	ga-du-cō	ga-du-zō
71		1	a-bo-ci	ab-či
71		5	bi-ye	be-ye
71		5	al-dar-šig-ci	al-dar-šig-či
71		7	ke-meg-ci	ke-meg-či
71		8	tō-ñī	tō-ñī
71		10-11	mür-[-]ged	mür-gēd
71		12-13	bur-han	bur-kan
71		14	ci	či
71		14	ci-nu	či-nu
71		15	ga-čar	ga-zar
71		15	ke-men	ke-mēn
71		17	nō-gō	nō-gō
71		17	čai ci-naŋ	cai či-naŋ
71		18	nab-ci	nab-či
71		18	a-ba-cou	ab-čō
71		19	nab-ci-gi	nab-či-gi
71		19	čō-cin	cō-čin
71		19	su-kui-dur	bu-küi-dur
71		21	cam-do	čam-do
71		21	nab-ci-ñi	nab-či-ñi
71		21	čo-gō-ciŋ	co-gō-čiŋ
71		22	ci-soŋ	či-soŋ
71		23	ci	či
71		24	e-je-leg-ci	e-je-leg-či
71		26	ci	či
71		27	i-neg-ši	i-nag-ši
71		28	čag-to	cag-to

71	15		i-re-kui-ge	i-re-kui-gi
71	13		o-lam	o-lom
71	13		do-kiş do-kiş ki-ku-dur	do-kiş ki-ku do-kiş ki-ku-dur
71	11		i-reg-sen-dur	i-reg-seŋ-dur
71	11		ye-ke-ken	ye-ke-keŋ
71	11-10		al-da-lan	al-da-laŋ
71	10		a-ri-suŋ-ni	a-ri-suŋ-ŋi
71	10-9		eb-[-]ci-ju	eb-çi-ju
71	8		te-re	ti-re
71	7		geg-ci	geg-çi
71	6		ü-kü-ci ag-san	ü-kü-çi ag-saŋ
71	4		şi-de-du	şi-di-du
71	3		al-dar-şiğ-san	al-dar-şiğ-saŋ
71	2		ko-go-soŋ-ni	ko-go-soŋ-ŋi
71	2		i-le-tu	i-le-te
71	1		o-gō-gā-at	o-gō-gā-ta
72		1	kob-ča-sun	kob-ca-sun
72		2	gag-ča	gag-ca
72		2	kob-ča-soŋ-ni	kob-ca-soŋ-ŋi
72		3	ü-zü-gü-lüg-ci	ü-zü-gü-lüg-çi
72		6	ci-meg	çi-meg
72		7	ga-da-nā	ga-da-na
72		7	do-to-na	do-to-nā
72		8	del-ge-re-kü-lüg-san	del-ge-re-kü-lüg-saŋ
72		8	me-deg-ci	me-deg-çi
72		10	i-za-gor	i-za-gor-do
72		11	su-dar	so-dor
72		12	če-ge-ji-leg-se	ce-ge-ji-leg-seŋ
72		12	čei-ge-ji-le-kū	cei-ge-ji-le-kū
72		17	ag-san	ag-saŋ
72		17	tī-mü	tē-mü
72		17-18	bi-leg[-]-tün	bi-leg[-]-tüŋ
72		18	i-nu	i-no
72		20	čag-dor-ŋi	cag-dor-ŋi
72		22	tī-mü	tē-mü
72		24	o-ha-gaŋ-no	o-ho-gaŋ-no
72		25	ci	çi
72		26	tos	to-sa
72		27	tos	to-sa

72	16		e-če	e-ce
72	13		er-güg-dig-sen	er-güg-dig-seŋ
72	12		ke-meg-ci	ke-meg-či
72	12		bo-log-san	bo-log-saŋ
72	9		na-so-lag-san	na-so-lag-saŋ
72	9		na-son-no	na-soŋ-no
72	7		nir-vaŋ	ñir-vaŋ
72	6		Bran-pü	Braŋ-pü
72	5		o-cir-no	o-čir-no
72	5		ke-le-mer-cī	ke-le-mer-čī
72	3		ko-liŋ-čag ē-ci-gē	ko-liŋ-cag e-či-gē
72	2		e-ci-ge	e-či-ge
72	1		e-ci-[-]	e-či-[-]
73		1	e-kü-ŋü	e-küŋ-nü
73		4	er-dem	e-ner-dem
73		4	ye-ke-e-se-čü	ye-ke e-se čü
73		7	dü-ciŋ	dü-čiŋ
73		8	teb-ci-kü	teb-či-kü
73		9-10	ča-[-]-gaŋ	ca-gaŋ
73		11	e-ci-ge	e-či-ge
73		11	ča-gaŋ	ca-gaŋ
73		13	ke-meg-ci	ke-meg-či
73		14	to-so-log-ci o-cir	to-so-log-či o-čir
73	13		Gün-	Güŋ-
73	8		ci-meg	či-meg
73	8		dü-ciŋ	dü-čiŋ
73	5		ke-meg-deg-ci	ke-meg-deg-či
73	5		ñi-gen	ñi-geŋ
73	1		ba-tod	ba-to-da
74		15	хааны	ханы
74	3		хонхороос	ховхорвоос?
74	3		суухал	бүхүйд
75		4	...тэр өдөр бүр энд ирдэг...	... тэр янагш одөр бүр ирдэг...
75		5	...гадаа гарч суугаад, Хар Ямандаг...	...гадаа гарч, Хар Ямандаг...
75		7	...мутраа дохис дохис хийхэд, бөхөс бөхөс хийсээр ирсэнд...	...мутраа дохис хийх дохис хийхэд тэр эм бөхөс бөхөс хийсээр шахаар ирсэнд...
75		17	...хамгийн оройн чимэг...	...бүгдийн оройн чимэг...
75		22	... даруй даруй сайн...	...даруй даруй дээр сайн...

75	20		Түүний хойно Сингали газар...	Түүний хойно Энэтхэгт Сингали газар...
75	7		Цүлтимнамжал	Цүлтимнамжал буюу.
76	7		Д. Гантогтохоор	Г. Гантогтохоор
88		6	Об одном новонайденном памятнике...	Об одном памятнике...
89	16		Агваанлувсандондовийн	Агваанлувсандондовын
93	4		хоёр зүйл дурсгалуудыг...	хоёр зүйл дурсгалыг...
94		6	Лекцы	Лекции
95		5	hᠭ	hᠭi
106		3	Лекцы	Лекции
117		6	...зургаан зүйлийн дурсгалууд...	...зургаан зүйлийн дурсгал...
120	3		Fasc.I., Budapest.	Fasc.I., Budapest.
129		1	unbekannt	unbekannte
129		5	D.Kara	G.Kara
130	6		D.Kara	G.Kara
131		3-4	a-mu-ta	a-mi-tan
132	11		conclution	conclusion
141	16		<i>Монголчуудын үсэг бичгийн товчоо</i>	<i>Монголчуудын үсэг бичгийн товчоон</i>
142	21		Reis	Reise
142	17		ьber	über
142	17		mongolischen Volkerschaften	mongolischen Völkerschaften
142	16		1801	1803
142	13		The Resaerch	The Research
142	11		Inascription	Inscription
142	8		среднеазиатских	среднеазиатских
142	3		Лекци	Лекции
142	2		Об одном новонайденном памятнике...	Об одном памятнике...

Төгсгөлд нь, эрдэмт лам Р.Бямбаагийн “Занабазарын дөрвөлжин үсэг” хэмээх номын ололттой сайн талыг нэгтгэн дүгнэвэл,

- 1987 оныг хүртэл хэвтээ дөрвөлжин үсгийн дөрөвхөн дурсгал мэдэгдээд байсныг 20 шинэ дурсгалаар нэмэн баяжуулж 24 болгосон. Үүгээр нь Пагба ламын дөрвөлжин үсгийн шинэ шинэ дурсгалыг сурвалжлан олж, судлан шинжилсэн БНХАУ-ын нэрт эрдэмтэн Зуунаст профессорын ач гавьяатай зүйрлэж болмоор санагдана.

- Уул үсгийн уламжлалт нэр болон зохиогдсон он цагийн талаар үндэслэгээтэй баримт нуталгаа дурдсан,

- Хэвтээ дөрвөлжин үсгийн дурсгалыг нэг дор цуглуулж, нягтлан шинжилсэн,

- Эх зохиолын үлгэр жишээ болохуйц тод сайхан гэрэл зургуудыг нийтлүүлсэн,
- Орчин үеийн эх бичиг судлалын шаардлагад бүрэн нийцсэн судалгаа хийсэн зэрэг болно.

Ийнхүү эрдэмтэн Р.Бямбаа хэвтээ дөрвөлжин үсэг, түүний дурсгалуудыг нягтлан шинжилсэн бүтээлүүдээрээ эл үсгийн судлалын талбарт нээлт хийгээд зогсоогүй, монгол үсэгзүйн нэгэн салаа салбарыг орчин үеийн дэлхийн монгол судлалын төвшинд хүргэсэн гавьяатай юм.

Тэр бээр тус номоо хэвлэснээс хойшхи 4-5 жилийн хугацаанд дахин шинэ шинэ дурсгал нээн олсон гэдэгт бид итгэн найдаж байхын зэрэгцээ, соёмбо үсгийн дурсгалуудыг судлан шинжилсэн бүтээлээ хэвлэн нийтлүүлэхийг нь хүсэн хүлээж байна.

Энэ тацрамд тэмдэглэхэд, хойшид хэвтээ дөрвөлжин үсгийн шинэ шинэ дурсгалыг уйгагүй эрэн сурвалжилж, хэвлэн нийтлэх, олдоод буй монгол, самгард, төвд хэлний бүх дурсгалын үгийн цэс (index)-ийг хэл тус бүрээр үйлдэх, ялангуяа монгол хэлний дурсгалуудыг үсэгзүй, авианзүй, бүтээвэрзүй, үгийн сангийн талаас буюу хэлшинжлэлийн үүднээс нягтлан судлах, эл үсгийн дурсгалын хэлийг соёмбо үсгийн ном зохиолын хэл болон XVII-XVIII зууны үеийн бусад сурвалжийн хэлтэй харьцуулан шинжлэх, тус үсгийн дурсгалуудын түүх, соёлын ач холбогдлыг тодруулах зэрэг ажлыг даруй хиймээр байгаа билээ.